



**ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 01

Зуунмод сум

Газрын нэгдмэл санг баталгаажуулах
тухай

Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарын өргөн мэдүүлсэн аймгийн Газрын нэгдмэл сангийн 2020 оны тайланг хэлэлцээд Монгол Улсын “Газрын тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалт, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газрын нэгдмэл сангийн тайлан гаргах журам”-ын 16 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн газрын нэгдмэл санг 7404237 га-гаар, үүнээс хөдөө аж ахуйн газар 5533200.4226 га, хот, тосгон, бусад суурин газар 95638.8123 га, Зам шугам сүлжээний газар 46263.5614 га, Ойн сангийн газар 573351.13 га, Усан сан бүхий газар 14285 га, Улсын тусгай хэрэгцээний газар 1141498.07 га-гаар тус тус батламжилсугай.

2. Аймгийн газрын нэгдмэл сангийн 2020 оны тайланг зохих журмын дагуу шаардлагын хэмжээнд гаргасан байна гэж дүгнэсүгэй.

3. Аймгийн газрын нэгдмэл сангийн 2020 оны тайланд үндэслэн Газрын тухай хууль тогтоомжийг чанд мөрдүүлэх, газрын харилцааг улам боловсронгуй болгох зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Мөнхбаатар/-д даалгасугай.


3.1 Монгол Улсын Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Кадастрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.1, 10.2.5 дахь заалтуудыг үндэслэн Газрын мэдээллийн сангийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, нөхөн бүрдүүлэлт, мэдээллийн баазын зөрчилтэй мэдээллийг бүрэн засварлаж дуусгах ажлыг шат дараатай арга хэмжээ авч зохион байгуулах.

4. Тайлант оны сумын газрын нэгдмэл сангийн тайланг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хуралдаанаар хэлэлцэн баталгаажуулж, аймгийн ГХБХБГазарт хүргүүлж хэвшихийг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

5. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Ч.Жавзанпагма/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ЖАМБАЛСҮРЭН



0100007